



Өвөрхангай аймгийн Бүрд сумын 5-р багт хогийн цэгийг ландфилийн аргаар устгаж булах, шинээр хогийн цэг байгуулах ажлыг хүлээлцэх акт

2023/11/30

Бүрд сум

Сумын засаг даргын 2023 оны 10 сарын 30-ний өдрийн А/98 тоот захирамжаар ажил хүлээлцэх комисс 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан.

Ажил хүлээлцэх комиссын хуралдаан нь дарга Б.Сандагдорж, гишүүд Б.Мөнхбаяр Э.Лувсанжамц-Оюундалай нарын бүрэлдэхүүнтэй 2023 оны 11-р сарын 30-ний өдөр 16:30 цагт Засаг даргын тамгын газрын өрөөнд 100 хувийн ирцийн бүртгэлтэй эхэлсэн. Хэлэлцэх асуудал: "Хогийн цэгийг ландфилийн аргаар устгаж булах, шинээр хогийн цэг байгуулах ажил"-ыг хүлээн авах.

Б.Сандагдорж:

Техникийн тодорхойлолтын дагуу хийсэн ажлыг нь нэг бүрчлэн шалгалаа. "Хогийн цэгийг ландфилийн аргаар устгаж булах, шинээр хогийн цэг байгуулах ажил" хангалттай гүйцэтгэсэн гэж үзэж хүлээн авах саналтай байна.

Б.Мөнхбаяр:

"Хогийн цэгийг ландфилийн аргаар устгаж булах, шинээр хогийн цэг байгуулах ажил" техникийн тодорхойлолтын дагуу 150*250 хэмжээтэй 3.75 га талбайд техникийн тодорхойлолтын дагуу баригдсан байна. Шаардлагатай бүх хэмжилтүүдийг хийж дууслаа. Уг ажлыг хүлээн авахад татгалзах зүйл байхгүй болно. Ажлыг хангалттай гүйцэтгэсэн гэж үзэж хүлээн авах саналтай байна.

Э.Лувсанжамц-Оюундалай:

Ажлыг хангалттай гүйцэтгэсэн гэж үзэж хүлээн авах саналтай байна.

Ө.Өлзий-Очир:




"Хогийн цэгийг ландфилийн аргаар устгаж булах, шинээр хогийн цэг байгуулах ажил" 100%-ийн гүйцэтгэлтэй тул хүлээлгэн өгөхөд татгалзах зүйлгүй ба уг ажлыг үүгээр хүлээлгэн өглөө.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Ажил хүлээлцэх комиссын гишүүдийн олонхын саналаар хогийн цэгийг ландфилийн аргаар устгаж булах, шинээр хогийн цэг байгуулах ажлыг хүлээн авахаар боллоо. Хуралдаан мөн өдрийн 17:20 цагт дуусав.

Тэмдэглэл хөтөлсөн:  Б. Мөнхбаяр

Хүлээн авсан:

Комиссын дарга:  Б.Сандагдорж /5-р багийн Засаг дарга/
Гишүүд:  Б.Мөнхбаяр /Байгаль орчны улсын хяналтын байцаагч/
 Э.Лувсанжамц-Оюундалай /Мал аж ахуй хариуцсан мэргэжилтэн/

Хүлээлгэн өгсөн:

"Өлгий ээж" ХХК-ний гүйцэтгэх захирал:  Ө.Өлзий-очир

